

“ЮНИВИШН” ХХК-ИЙН ОЛОН СУВАГ ДАМЖУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СҮЛЖЭЭНД ХОЛБОГДОХ НӨХЦӨЛ (RAO)

Энэхүү баримт бичгээр Телевизийн үйлчилгээ эрхлэгчтэй байгуулах Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн Холболтын гэрээний нөхцөлийг тодорхойлсон ба Харилцаа холбооны зохицуулах хороо (цаашид “Зохицуулах хороо” гэх)-ны 2021 оны 33 тоот тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Сүлжээ хооронд харилцан холболт хийх гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журам” (цаашид “Холболтын журам” гэх)-ын 2.5 дах хэсэгт заасныг баримтлан боловсруулсан болно.

“Юнивишн” ХХК нь олон суваг дамжуулах үйлчилгээг _____ тоот тусгай зөвшөөрөлтэйгөөр Монгол улсын хэмжээнд хүргэдэг.

НЭГ. ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

1. Нийлүүлэгч нь дор дурдсан шаардлагын дагуу Сувгийг харилцан холболтын ЗААГЛАХ ЦЭГ буюу Юнител ХХК-ийн Дата төвд хүргэнэ.
2. Нийлүүлэгчийн нэвтрүүлгийн чанар нь MNS-5592-2 стандартын тоон телевизийн үндсэн үзүүлэлтүүдийн дагуу дараах хүснэгтэд заасан шаардлагыг хангасан байна.

а. ИНТЕРФЕЙС

Дүрсний оролт	SMPTE 259M (SD-SDI) /Хэрвээ HD форматаар дамжуулах бол SMPTE 292M (HD-SDI)/
Дууны оролт	Embedded audio (Дүрсний сигналд нь суулгасан аудио сигнал)

б. ДҮРСНИЙ ҮЗҮҮЛЭЛТ

Дүрсний харьцаа	4:3 /Хэрвээ HD форматаар дамжуулах бол 16:9/
SD нягтрал болон фреймрейт	576i@25
HD нягтрал болон фреймрейт	1080i@25

с. ДУУНЫ ҮЗҮҮЛЭЛТ

Дууны кодлол	Стерео хос
Дууны түвшин	-18dbFs (0db) EBU R128 мөрдөх

3. Дамжуулагч нь Нийлүүлэгчийн Сувгийг дараах стандартын дагуу сансрын хиймэл дагуулаар дамжуулж хэрэглэгчдэд хүргэнэ.

а. ДҮРСНИЙ ҮЗҮҮЛЭЛТ

Дүрсний шахалт болон битрейт H.264 4:2:0 кодлуур	
MPEG-4 MP@ML	SD 0.3 to 5 Mbps (VBR) /HD 0.3 to 15 Mbps (VBR)/
Дүрсний харьцаа	SD 4:3 /HD16:9/

б. ДУУНЫ ҮЗҮҮЛЭЛТ


Дууны формат	MPEG-1 Layer I, MPEG-1 Layer II
Дууны кодлол	Stereo

1. Дээрх стандартуудад нийцсэн эсэхэд чанарын үнэлгээ өгөх хэмжилт нь **УЛИРАЛД НЭГ УДАА** хийгдэнэ. Дамжуулагч нь Нийлүүлэгчээс шалтгаалан Сувагт гарсан гологдол, саатлыг Нийлүүлэгчид мэдэгдэж, гологдол, саатлыг арилгахыг шаардана.
2. “ЗААГЛАХ ЦЭГ”-д буюу Дата төв дээр ирж буй Нийлүүлэгчийн шилэн кабелийн үзүүр болон төхөөрөмж нь тухай телевизийн Дамжуулагчид өгч буй дамжуулалтын хувьд эцсийн цэг байна.
3. Нийлүүлэгчийн Сувгийн студиас “ЗААГЛАХ ЦЭГ”-ын хувиргалтын төхөөрөмжийн оролт хүртэлх дамжуулалтын трактын /оптик төхөөрөмж/ хэвийн найдвартай ажиллагааг хангах асуудлыг Нийлүүлэгч бүрэн хариуцна.

ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН МЭДЭЭЛЭЛ

Холболтын техник, төхөөрөмжийн нэр, зориулалт	Нийлүүлэгч талд УБ	Нийлүүлэгч талд ОН	Дамжуулагч талд(ОСДҮЭ)
Хөрвүүлэх төхөөрөмж (Encoder) түүний төрөл, марк, дугаар		“Dexin” Encoder	“Envivio” encoder
Дамжуулах(Тх)/Хүлээн авах(Rx) төхөөрөмж түүний төрөл марк, сериал дугаар	Blackmagic Mini converter Optical Fiber	ONT or MDU	Blackmagic Mini converter Optical Fiber
Холбох шугамын төрөл, үзүүлэлт		Шилэн кабель	Телевизээс Дата төв хүртэл шилэн кабель 1 core шууд холболт
Холболтын интерфэйс	HD-SDI embeded signal телевизээс өгч Дата төв дээр хүлээн авна.	HD-SDI embeded signal телевизээс өгч Дата Центр төв дээр хүлээн авна.	HD-SDI embeded signal телевизээс өгч Дата Центр төв дээр хүлээн авна.
Бусад			

ХОЁР. СУВАГ БОЛОН ДАМЖУУЛАГЧИЙН СҮЛЖЭЭ ХООРОНДЫН ХАРИЛЦАН ХОЛБОЛТЫН ЗААГЛАХ ЦЭГ, ЗУРАГЛАЛ(УЛААНБААТАР ХОТ)




(Зааглах цэг нь УБ хот ХУД 4-р хороо Дата Центр 3 давхар G-1 зогсуур)

(Орон нутгийн телевизтэй байгуулах гэрээнд орох хувилбар)

ХОЁР. СУВАГ БОЛОН ДАМЖУУЛАГЧИЙН СҮЛЖЭЭ ХООРОНДЫН ХАРИЛЦАН ХОЛБОЛТЫН ЗААГЛАХ ЦЭГ,

ЗУРАГЛАЛ (ОРОН НУТАГ)



(Зааглах цэг нь Орон нутаг дахь Мэдээлэл Холбооны Сүлжээ ХХК-ийн байр)

ГУРАВ. ТЕЛЕВИЗИЙН СУВГИЙГ ДАМЖУУЛАХТАЙ ХОЛБООТОЙ ЗАРДАЛ

№	Зардлын нэр төрөл	Холболтын төрөл	Суваг дамжуулалтын төлбөр ₮	
			УБ хот	Орон нутаг
1	Шилэн кабель, урсгал түрээсийн төлбөр	HD	...₮	...₮

Тайлбар:

“Сүлжээ хооронд харилцан холболт хийх, сүлжээнд холбогдох гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журам”-ын 2.9-д зааснаар дээрх төлбөрийн хэмжээг тогтоохдоо бизнесийн аливаа алдагдлыг нөхөх зорилго агуулахгүй байх зарчмыг баримтална.

ТАЛУУДЫН ХАРИЛЦАН ХОЛБОО БАРИХ МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН МЭДЭЭЛЭЛ

“UNIVISION” ХХК-ний зүгээс:

1.	Техникийн холбогдолтой асуудал гарсан үед:	Сүлжээ хяналтын инженер, утас: 77007740, 89118042, и-мэйл хаяг: omc@unitel.mn
2.	Санхүүгийн холбогдолтой асуудал гарсан үед:	М. Отгонжаргал /Нягтлан бодогч,/ Утас: 86110987, и-мэйл хаяг: otgonjargal.m@unitel.mn
3.	Маркетингийн холбогдолтой асуудал гарсан үед:	Т. Лхам Төлөвлөлтийн ахлах мэргэжилтэн Утас: 89110263, и-мэйл хаяг: lkham.t@unitel.mn
4.	Гэрээ болон контентын асуудал гарсан үед:	Т. Дунгаамаа Медиа хамтын ажиллагааны мэргэжилтэн Утас: 89118885 и-мэйл хаяг: dungaamaa.t@unitel.mn

Нийлүүлэгчийн зүгээс:

1.	Техникийн холбогдолтой асуудал гарсан үед:
2.	ТВ-ийн хөтөлбөртэй холбоотой өөрчлөлт гарсан үед:
3.	Санхүүгийн холбогдолтой асуудал гарсан үед:
4.	Маркетингийн холбогдолтой асуудал гарсан үед:

Тайлбар:

Гэмтэл, сааталтай холбоотой тусгай журамлал: Аль нэг талд техниктэй холбоотой ямар нэг гэмтэл, саатал, асуудал гарсан тохиолдолд шаардлагатай гэж үзвэл талуудын инженерүүд бие биетэйгээ түргэн, шуурхай холбогдож, хамтран ажиллаж, тухайн асуудлыг шийдвэрлэхийг эрхэмлэнэ. Нийлүүлэгчийн зүгээс техниктэй холбоотой ямар нэг гэмтэл, саатал, асуудал гарсны улмаас Ай Пи Ти Ви доголдож улмаар хэрэглэгч, үзэгчдийн зүгээс гомдол, санал гаргах, Ай Пи Ти Ви-ийн үйлчилгээ, нэр хүндэд сөргөөр нөлөөлөх аливаа нөхцөл байдал олон нийт, нийгмийн сэтгэл зүйд үүсэх, эсхүл ийм нөхцөл байдал хэдийн үүссэн байдаг тул Ай Пи Ти Ви-ийн зүгээс дээрх хүснэгтэд нэр дурдсан эсэхээс үл хамааран тухайн телевизийн холбогдох албан тушаалтан, шууд удирдлага зэрэгтэй холбоо барин шаардлагатай инженер, техникийн ажилтантай холбож өгөх талаар санал болгох эрхтэй. Тухайн телевизийн холбогдох албан тушаалтан, шууд удирдлага нь энэхүү санал, хүсэлтийг хүлээн авч, найрсаг, түргэн шуурхайгаар зохицуулж өгөх арга хэмжээ авах үүрэг хүлээнэ.

ТАВ. ГЭРЭЭНИЙ ЗАГВАР

СУВАГ ДАМЖУУЛАХ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ

202[•] оны [•] сарын [•]-ны өдөр

№

Улаанбаатар хот

Энэхүү Суваг дамжуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээ (цаашид “**Гэрээ**” гэх)-г

Нэг талаас 5388457 дугаартай “Юнивишн” ХХК, түүнийг төлөөлж Медиа менежментийн албаны захирал Г.Болорчимэг (цаашид “**Дамжуулагч**” гэх)

Нөгөө талаас [•] регистрийн дугаартай “[•]” ХХК, түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал [•] (цаашид “**Нийлүүлэгч**” гэх) нар нь

Монгол Улсын Иргэний хууль, Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, Сүлжээ хооронд харилцан холболт хийх, сүлжээнд холбогдох гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журам болон бусад холбогдох хууль тогтоомжийг тус тус удирдлага болгон доорх нөхцөлтэйгөөр харилцан тохиролцож, байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Дамжуулагч нь өөрийн Ай Пи Ти Ви-ийн [•] **дугаарлалт дээр** Нийлүүлэгчийн телевизийн суваг болох “[•] ” (**цаашид “Суваг” гэх**)-г байршуулан, өөрийн олон суваг дамжуулах платформоор дамжуулах, Нийлүүлэгч нь Сувгийг дамжуулахтай холбоотой зардлыг төлөхтэй холбоотой харилцааг энэхүү гэрээгээр зохицуулна.
- 1.2 Гэрээ нь Талуудын төлөөлөл, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал, үүсгэн байгуулагчид, өмчлөгчид нь өөрчлөгдсөнөөс үл хамааран гэрээний хугацаанд хүчин төгөлдөр байна.
- 1.3 Гэрээ нь талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болж, энэхүү Гэрээнд заасны дагуу Гэрээ цуцлагдах, эсхүл дуусгавар болох хүртэл хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 1.4 Нийлүүлэгчийн нийлүүлэх суваг нь дараах шаардлагыг хангасан байна.
 - 1.4.1 Монгол Улсын Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай, патент, барааны тэмдэг, оюуны өмчтэй холбогдох бүхий л хуульд нийцсэн байх;
 - 1.4.2 Монгол Улсын Зар сурталчилгааны тухай, Өргөн нэвтрүүлгийн тухай болон Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль зэрэг Монгол улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад холбогдох хууль, тогтоол, журамд нийцсэн байх;
 - 1.4.3 Нийгмийн сэтгэл зүйд сөргөөр нөлөөлөх, хүний эрх, эрх чөлөөний эсрэг агуулга, гэмт хэрэг, аливаа төрлийн хүчирхийлэл, дарамт, садар самууныг сурталчилсан, энгийн болгож харуулсан, үндэстэн, ястан болон шашин хоорондын мөргөлдөөнд уриалсан, өдөөн хатгасан; арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, улс төрийн итгэл үнэмшил, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, үзэл бодол, бэлгийн чиг хандлага, хөгжлийн бэрхшээлийнх нь улмаас хувь хүн буюу тодорхой бүлгийг үзэн ядах, ялгаварлан гадуурхсан агуулга, дүрслэлгүй, үзэгчийн мэдээллийн тэнцвэртэй байдлыг хангасан байх;
- 1.5 Дараах хавсралтууд нь Гэрээний салшгүй хэсэг болно.
 - 1.5.1 Хавсралт 1. Техникийн нөхцөл
 - 1.5.2 Хавсралт 2. Харилцан мэдээлэл солилцох
 - 1.5.3 Хавсралт 3. Сувагт гарсан гэмтэл саатлыг тооцох тухай
 - 1.5.4 Хавсралт 4. Хөтөлбөр өгөх формат
 - 1.5.5 Хавсралт 5. Зардал
 - 1.5.6 Хавсралт 6. Тоног төхөөрөмжийн мэдээлэл

ХОЁР. ДАМЖУУЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 2.1 Дамжуулагч нь дараах эрхийг эдэлнэ:
 - 2.1.1 Гэрээний 1.1-т заасны дагуу Суваг дамжуулах үйлчилгээ үзүүлэх хугацаандаа Гэрээний Хавсралт 5-д заасан зардлыг төлөхийг Нийлүүлэгчээс шаардах;
 - 2.1.2 Нийлүүлэгчээс хамаарсан гэмтэл, саатлын улмаас эфирийг тасалдуулсан тохиолдолд Дамжуулагч нь энэ талаар хэрэглэгчдэд мэдээлэл хүргэх;
 - 2.1.3 Дамжуулагч Сувгийг дамжуулахад шаардагдах Нийлүүлэгчийн гаргаж өгсөн бичиг баримт, мэдээлэл болон тоног төхөөрөмж нь шаардлага хангахгүй тохиолдолд доголдолыг арилгахыг шаардах;

- 2.1.4 Нийлүүлэгч нь Дамжуулагчийн албан ёсны эрхтэй аливаа контентийг зөвшөөрөлгүйгээр Сувгаар гаргахгүй байхыг болон гэрээнд заасан үүргээ зохих ёсоор биелүүлэхийг нийлүүлэгчээс шаардах;
- 2.1.5 Нийлүүлэгчийн буруутай үйл ажиллагааны улмаас эсхүл Гэрээнд заасан дамжуулалтын зардлыг төлөөгүйн улмаас Дамжуулагчид хохирол учирсан тохиолдолд хохирлоо нөхөн төлүүлэх;
- 2.1.6 Байгалийн гамшиг, олон нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, халдварт өвчин гарах, онц ноцтой гал түймэр дэгдэх, дайны болон онц байдал зарлах, зэрэг гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл тохиолдсны улмаас эрх бүхий байгууллагын үүрэг болгосны дагуу Нийлүүлэгчийн ямар ч нэвтрүүлгийн дундуур тухайн байдлын талаар олон нийтэд мэдээлэл хийх;
- 2.1.7 Дамжуулагч нь Нийлүүлэгчийн сувгийг өөрийн OTT платформоор дамжуулах;
- 2.1.8 Хуульд заасан бусад эрх;
- 2.2 Дамжуулагч дараах үүргийг хүлээнэ:
 - 2.2.1 Дамжуулагч нь Сувгийг техникийн доголдолгүй дамжуулах үүднээс ажил үүргийг зохих мэргэжлийн ур чадвар бүхий хүмүүсээр хийж гүйцэтгүүлэх;
 - 2.2.2 Дамжуулагч нь өөрийн сүлжээний найдвартай байдлыг хангаж, гаднын халдлагаас хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллах;
 - 2.2.3 Ай Пи Ти Ви-ээр Суваг дамжуулах үйлчилгээг гэрээний хугацаанд чанартай, тогтвортой явуулж, Сувгийг өөрийн багцуудад оруулан хэрэглэгчдэд дамжуулах;
 - 2.2.4 Нийлүүлэгчийн сувгаар оюуны өмчийн албан ёсны эрхтэй контентийг зөвшөөрөлгүй нэвтрүүлсэн нь тогтоогдсон тохиолдолд Дамжуулагч нь энэ тухай Нийлүүлэгчид мэдэгдэх;

ГУРАВ. НИЙЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1 Нийлүүлэгч нь дараах эрхийг эдэлнэ:
 - 3.1.1 Дамжуулагчийн үзүүлж буй үйлчилгээ болон хийгдэж буй ажлууд нь чанарын шаардлага хангахгүй гэж үзвэл санал гаргах, шаардлага тавих;
 - 3.1.2 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг эсхүл зохих ёсоор буюу шударгаар биелүүлэхийг нөгөө талаас шаардах;
 - 3.1.3 Техник, тоног төхөөрөмжид үзлэг шалгалт хийх зэрэг тохиолдолд урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр эфирийг зайлшгүй хаах;
 - 3.1.4 Гэрээнд заасан нөхцөлийн дагуу Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, гэрээний хугацааг сунгах тухай санал гаргах;
 - 3.1.5 Дамжуулагчийн буруутай үйлдэл нь эрх бүхий байгууллагаас тогтоогдсон тохиолдолд уг үйлдлийн улмаас өөрт учирсан хохирлоо арилгуулахаар шаардах;
 - 3.1.6 Сүлжээний найдвартай, тасралтгүй ажиллагаа, аюулгүй байдлыг бүрэн хангахыг шаардах;
 - 3.1.7 Гэрээний явцад харилцан хяналт тавих, зөрчил дутагдлыг хугацаа тогтоон засахыг шаардах; болон
 - 3.1.8 Хуульд заасан бусад эрх;
- 3.2 Нийлүүлэгч нь дараах үүргийг хүлээнэ:
 - 3.2.1 Хөтөлбөрийн дуу дүрсний дохиог Дамжуулагчийн шаардсан техникийн нөхцөл Хавсралт 1-д заасны дагуу нийцүүлсэн байх,
 - 3.2.2 **Хавсралт 1-т** заасан “Зааглах цэг”-т өөрийн эфирийг шилэн кабелиар авчирсан байх;
 - 3.2.3 Дамжуулагчаас өгсөн техникийн нөхцөл, шаардлагыг хангах техник тоног төхөөрөмжтэй байх, тэдгээрийн ашиглалт үйлчилгээ хэвийн найдвартай ажиллагааг гэрээний хугацаанд тогтвортой хангаж ажиллах;
 - 3.2.4 Гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлэхэд шаардагдах аливаа тусгай зөвшөөрөл, лицензийг зохих журмын дагуу, цаг тухайд нь эрх бүхий байгууллагаас авч, хүчин төгөлдөр байдлыг нь гэрээний хугацаанд хэвээр хадгалах;
 - 3.2.5 Гэрээнд заасан зардлыг гэрээнд заасан хугацаа, хуваарийн дагуу Дамжуулагчид төлж байх;
 - 3.2.6 Суваг нь долоо хоног бүрийн Баасан гарагийн 14:00 цагаас өмнө **Хавсралт 2-т заасан** мэйл хаягаас Дамжуулагчийн tv@unitel.mn и-мэйл хаягруу нэвтрүүлгийн хөтөлбөрийг Хавсралт 1-т заасан форматын дагуу илгээнэ.
- 3.2.7 Хөтөлбөрийн засварыг засвар орох хөтөлбөрөөс хамгийн багадаа 24 цагийн өмнө ажлын цагт багтаан tv@unitel.mn хаягаар Хавсралт 1-т заасан Хөтөлбөрийн засвар хэсэгт заасны дагуу илгээнэ.
- 3.2.8 Дамжуулагчийн албан ёсны эрхтэй аливаа контентийг урьдчилсан бичгэн зөвшөөрөлгүйгээр өөрийн сувгаар гаргахгүй байх;
- 3.2.9 Олон суваг дамжуулах тусгай зөвшөөрөлгүй аливаа аж ахуйн нэгжтэй холболт хийхгүй байх;

- 3.2.10 Дамжуулагчаас хамааралгүйгээр аливаа техникийн саатал гарсны улмаас суваг гарахгүй болсон тохиолдолд Нийлүүлэгч нь “МАНАЙ СУВГИЙН ТЕХНИКТЭЙ ХОЛБООТОЙ ЭФИРИЙН СААТАЛ ГАРСАН ТУЛ ХҮЛЦЭЛ ӨЧЬЕ” гэсэн утга, агуулгатай мэдэгдлийг өөрийн сувгийн дэлгэц дээр байршуулах;
- 3.2.11 Тоног төхөөрөмжтэй холбоотой өөрчлөлт, түр зогсолт, техникийн шинэчлэл хийгдэх, байршил солих гэх мэт зорилгоор эфирээ таслах буюу зайлшгүй зогсолт хийх тохиолдолд Дамжуулагч талд хуанлийн (7) хоногийн өмнө бичгээр болон и-мэйлээр, Харилцаа Холбооны Зохицуулах Хороонд (72) цагийн өмнө, хэрэглэгчид (48) цагийн өмнө урьдчилан мэдэгдэх;

ДӨРӨВ. ТӨЛБӨР ТООЦОО

- 4.1 Анх удаа холбогдож буй Нийлүүлэгч нь Дамжуулагчаас тогтоосон анхны холболтын зардлыг Дамжуулагчид 100% төлөх үүрэгтэй бөгөөд Дамжуулагч нь холболтын нийт ажлыг гүйцэтгэнэ. Энэхүү заалт нь зөвхөн анх удаагаа холболт хийж байгаа Нийлүүлэгчид хамаарна.
- 4.2 Нийлүүлэгч байршлаа сольсон тохиолдолд шилэн кабель татах болон сигнал/дохио хүлээн авах тоног төхөөрөмжийн холбоотой гарах зардлыг Нийлүүлэгч бүрэн хариуцна.
- 4.3 Нийлүүлэгч нь Гэрээний 4.1-д заасан анхны холболтын зардлаас гадна телевизийн сувгийг дамжуулахтай холбоотой жилийн зардлыг Хавсралтаас дагуу Дамжуулагчид төлөх үүрэгтэй.
- 4.4 Нийлүүлэгч нь Хавсралт 5-д тусгасан зардлыг нэхэмжлэхийн дагуу Дамжуулагчид шилжүүлнэ.
- 4.5 Энэхүү гэрээний Хавсралт 2-т заасан талуудын санхүүгийн албаны холбогдох ажилтнууд нь төлбөр тоцоог улирал бүр нийлнэ.

ТАВ. АШИГЛАЛТ ҮЙЛЧИЛГЭЭ, ХАРИЛЦАН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ

- 5.1. Дамжуулагч нь Нийлүүлэгчийн Сувгийг (24) цагийн турш Ай Пи Ти Ви-ээр тасралтгүй цацах үйлчилгээг үзүүлэх ба ингэхдээ Талууд харилцан тохиролцоноос бусдаар уг хугацааг тасалдуулахгүй.
- 5.2. Дамжуулагч нь тоног төхөөрөмждөө үзлэг, үйлчилгээг хийх зорилгоор техникийн бүрэн зогсолтыг улиралд (1) удаа 00:00 цагаас 06:00 цагийн хооронд хийж байх бөгөөд энэ хугацаанд Сувгийг дамжуулахгүй.
- 5.3. Гэрээний Хавсралт 1-т заасан зааглах цэгт байрлуулсан Нийлүүлэгчийн тоног төхөөрөмжийн ашиглалт үйлчилгээг Дамжуулагч хариуцан ажиллах бөгөөд уг төхөөрөмжид техникийн горим алдагдсан буюу Дамжуулагчийн буруутай үйл ажиллагааны улмаас эвдэрч гэмтсэнээс бусад байдлаар гэмтэл гарсан тохиолдолд Дамжуулагч хариуцахгүй.
- 5.4. Дамжуулагч нь сар бүр нэвтрүүлгийн дуу дүрсний чанарын нэгдсэн үнэлгээг хийх ба Нийлүүлэгч нь өөрийн талаас хэмжилт хийх нөхцлийг бүрдүүлнэ. Нийлүүлэгчийн дуу дүрсний чанар, техникийн норм болон стандартад нийцэхгүй байгааг Харилцаа холбооны зохицуулах хорооноос мэдэгдэж арга хэмжээ авахыг сануулсан тохиолдолд Дамжуулагч нь дамжуулалтыг зогсоох хүртэл арга хэмжээ авна.
- 5.5. Үйлчилгээг хэвийн, чанартай, тасралтгүй явуулахын тулд шаардлагатай мэдээллүүдийг Талууд харилцан солилцох бөгөөд солилцож буй мэдээллийн нууцлалыг хамгаална.


ЗУРГАА. ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

- 6.1 Харилцан холболт хийх техникийн үзүүлэлтийн талаарх зохицуулалт:
- 6.1.1 Талуудын холболтын болон дамжуулах байгууламжийн төрөл марк, интерфейсүүд, харилцан холбогдоход шаардагдах бусад техник төхөөрөмж, багтаамж, тоо ширхэг зэрэг нь Хавсралт 1-ийн дагуу байна. Хавсралт 1-д орсон нэмэлт өөрчлөлтүүдийг тухай бүр бичгээр тусгаж байна.
- 6.1.2 Сүлжээ хоорондын дамжуулах видео сигнал нь стандартыг хангасан байх ба энэ нь хэрэглэгчид рүү дуу дүрсний чанар хангасан өргөн нэвтрүүлгийн хөтөлбөрийг дамжуулах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 6.1.3 Талуудын харилцан холболтын шугам нь өндөр хурдны оптик сүлжээ байна.
- 6.2 Зааглах цэгийн талаарх зохицуулалт:
- 6.2.1 Сүлжээний зааглах цэгүүдийн байршил Хавсралт 1-т заасны дагуу байна.
- 6.2.2 Зааглах цэг дэх техник, тоног төхөөрөмжийн ашиглалт, үйлчилгээг гэрээнд заасны дагуу талууд хариуцна.
- 6.2.3 Сүлжээ хоорондын харилцан холболтын зураглал нь Хавсралт 1-т заасны дагуу байна.
- 6.2.4 Талууд зааглах цэгээс (2) тийш шугамыг таслан шалгалт, хэмжилт хийх техникийн боломж, нөхцөлийг хангасан байна.
- 6.3 Сүлжээний ачааллын талаарх зохицуулалт:

- 6.3.1 Талууд өөрсдийн харилцан холболтын техникүүд (хувиргах, дамжуулах төхөөрөмжүүд болон сигнал дамжуулах бүх төрлийн кабелиуд)-ийн найдвартай ажиллагаа, бүрэн бүтэн байдлыг ханган ажиллана.
- 6.3.2 Нийлүүлэгчээс эфирийн гаралтын дуу дүрсний форматаа өөрчлөх (Техникийн өөрчлөлт болон шинэчлэлт) тохиолдолд ажлын 10-15 өдрийн өмнө Дамжуулагчид урьдчилан мэдэгдэн харилцан тест хийж, талууд сувгийн үйлчилгээний хэвийн ажиллагааг хангах тал дээр хамтран ажиллана.
- 6.3.3 Харилцан холболтын гэрээний хугацаанд хийгдэх техник тоног төхөөрөмжийн өргөтгөл, өөрчлөлт нь харилцан холбогдогч Талуудын үйлчилгээнд нөлөөлөхүйц байвал энэ талаарх мэдээллийг (72) цагаас доошгүй хугацааны өмнө нөгөө талдаа мэдэгдэх ба асуудлыг Талууд хамтран шийдвэрлэнэ.

ДОЛОО. ОЮУНЫ ӨМЧИЙН ХАРИЛЦАА

- 7.1 Дамжуулагч нь Нийлүүлэгчийн албан ёсны логог дамжуулахдаа түүний хэлбэр дүрс, өнгө зэрэгт ямар нэг байдлаар өөрчлөлт оруулалгүйгээр дамжуулна.



- 7.2 Нийлүүлэгч нь өөрийн албан ёсны логог Дамжуулагчийн dungaamaa.t@unitel.mn хаягаар цахим хэлбэрээр өгнө.
- 7.3 Телевизийн хөтөлбөр бэлтгэх, хүргэх үйл ажиллагаанд оюуны өмчийг дээдлэх, оюуны өмчийн зөрчилтэй Талууд хамтран тэмцэнэ.
- 7.4 Дамжуулагч нь Нийлүүлэгчийн албан ёсны логог дамжуулж буй телевизийн сувгуудыг дурдах зорилгоор олон суваг дамжуулах үйлчилгээний танилцуулга, сурталчилгаанд ашиглах эрхтэй. Ингэхдээ түүний хэлбэр дүрс, өнгө зэрэгт ямар нэг байдлаар өөрчлөлт оруулахгүйгээр ашиглана.
- 7.5 Дамжуулагч нь сувгийн хөтөлбөрийг дахин дамжуулж буй эсэхийг хянах зорилгоор Нийлүүлэгчид урьдчилан мэдэгдэж, телевизийн сувгийн хөтөлбөр дээр өөрийн лого эсхүл таних тэмдгийг тунгалаг байдлаар байрлуулах эрхтэй бөгөөд ингэхдээ Нийлүүлэгчийн логог дарахгүй байна.

НАЙМ . НИЙЛҮҮЛЭГЧИЙН МЭДЭГДЭЛ, БАТАЛГАА

- 8.1 Нийлүүлэгч нь дараах мэдэгдэл, баталгааг гаргаж байна. Үүнд:
 - 8.1.1 Нийлүүлэгч нь энэхүү гэрээний дагуу хүлээсэн бүхий л үүргээ хэрэгжүүлэх хангалттай ур чадвар, туршлага, хүний нөөцийн болон санхүүгийн чадвартай, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, үйл ажиллагаа явуулах эрхтэй ба уг зөвшөөрөл, эрх нь гэрээний хугацаанд хүчинтэй байна.
 - 8.1.2 Нийлүүлэгч нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх болон бусад бүхий л үйл ажиллагаандаа холбогдох хууль, дүрэм журмыг мөрдөн ажилладаг, ажиллах ба нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахуун, ёс зүйн хэм хэмжээнд харшилсан, Дамжуулагчийн нэр хүндэд харшлахуйц, үнэт зүйлд үл нийцсэн үйл ажиллагаа явуулахгүй.
 - 8.1.3 Нийлүүлэгч нь Дамжуулагчийн ажилтан, эрх бүхий этгээдэд ямарваа мөнгөн болон мөнгөн бус хэлбэрээр үнэ бүхий зүйл, давуу байдал санал болгоогүй, амлаагүй, олгоогүй ба хэлэлцээр хийх, гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилттэй холбоотой шийдвэр гаргах явцад шударга бусаар нөлөөлөөгүй, холбогдох Авлигын эсрэг хууль тогтоомжийг мөрдөж ажилладаг, ажиллах болно.
 - 8.1.4 Нийлүүлэгч, түүний ажилтан, эрх бүхий этгээд нь Олон Улсын болон Монгол Улсын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг холбогдох хууль тогтоомжтой танилцсан, тэдгээрийг зөрчөөгүй, зөрчихгүй ба тэдгээрт нийцүүлэх үйл ажиллагаа явуулан, ийнхүү шаардлагатай арга хэмжээг авч ажиллана.
 - 8.1.5 Нийлүүлэгч нь энэхүү гэрээг байгуулах эрх зүйн бүрэн чадвар, чадамжтай бөгөөд энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх нь Нийлүүлэгчийн дүрэм, журам болон ижил төрлийн бусад баримт бичгийн нөхцөлтэй зөрчилдөхгүй, аливаа гуравдагч этгээдээс зөвшөөрөл авах шаардлагагүй болно.
 - 8.1.6 Нийлүүлэгч нь Дамжуулагчийн ажилтан болон эрх бүхий этгээдтэй гэр бүлийн харилцаагүй эсхүл бусад байдлаар ашиг сонирхлын зөрчилгүй, ийнхүү сонирхлын зөрчилтэй тохиолдолд энэ талаар урьдчилан мэдэгдсэн болно.

ЕС. ТАЛУУДЫН ХАРИУЦЛАГА

- 9.1 Талуудын аль нэг нь Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас нөгөө талд хохирол учирсан бол хохирсон тал өөрийн хохирлын хэмжээг нотлох үүрэгтэй бөгөөд буруутай тал нь нөгөө талд учирсан бодит хохирлыг Гэрээнд болон хууль тогтоомжид заасны дагуу нөхөн төлнө. Бодит хохирол гэдэгт үүргийн гүйцэтгэлийг хангахад гарсан зардал, учирсан гэмтэл, алдагдал, өмгөөлөгчийн хөлс, шүүх нотариатын зардал зэргийг ойлгоно.
- 9.2 Нийлүүлэгч нь энэхүү гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй эсхүл зохих ёсоор биелүүлээгүй бол хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,5 хувиар тооцож, Дамжуулагчид алданги төлнө.
- 9.3 Нийлүүлэгч нь гэрээнд заасан үүргээ 2 ба түүнээс дээш удаа биелүүлээгүй, гэрээнд заасан мэдэгдэл, баталгаа хэсэг дэх заалтыг зөрчсөн тохиолдолд Хвсралт 5-д заасан үнийн дүнгийн 10% (арван хувь)- тай тэнцэх хэмжээний торгуулийг төлөх үүрэгтэй.
- 9.4 Нийлүүлэгч нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэхгүй эсхүл удаа дараа (2 ба түүнээс дээш удааг ойлгоно) биелүүлээгүй тохиолдолд Дамжуулагч нь үүргийн гүйцэтгэлийг хангаж, зөрчил арилах хүртэл харилцан холболтыг хязгаарлах эрхтэй. Үүнд:
 - 9.4.1 Нийлүүлэгч нь төлбөр төлөх хугацаан гэрээнд зааснаас 3 (гурав) сараар хэтрүүлсэн;
 - 9.4.2 Нийлүүлэгч нь хуанлийн 7 (долоо) хоногоос дээш хугацаанд эфирийн сигналыг нийлүүлээгүй тохиолдолд;
- 9.5 Талууд дор дурдсан болон хууль тогтоомжид зааснаас бусад тохиолдолд харилцан холболтыг салгах, хязгаарлалт хийхгүй. Үүнд:
 - 9.5.1 Гэрээний 9.4-т заасны дагуу;
 - 9.5.2 Техникийн гэмтэл саатал гарсан, эсвэл засвар, үзлэг шалгалт хийхээр харилцан тохиролцсон;
- 9.6 Нийлүүлэгч нь Дамжуулагчийн тоног төхөөрөмжөөр дамжин хэрэглэгчдэд очиж байгаа Сувгийн чанар, стандартад хяналт тавих, зохиогчийн эрхээр хамгаалагдсан телевизийн нэвтрүүлэг, дуу, дүрс, кино зэргийг зохих зөвшөөрөлгүйгээр нэвтрүүлсэн, эсхүл Зар сурталчилгааны болон бусад хууль тогтоомжийн зөрчилтэй нэвтрүүлэг контент цацсан зэрэгтэй холбоотой хариуцлагыг бүрэн хүлээнэ.
- 9.7 Энэхүү гэрээний дагуу Дамжуулагчийн хүлээх нийт хариуцлага нь гэрээний үнийн дүнгийн 20% (хорин хувь)-аас хэтрэхгүй байна.
- 9.8 Дамжуулагч нь Сувгаар цацагдаж буй мэдээ, мэдээлэл болон контентод ямарваа нэгэн хариуцлага хүлээхгүй бөгөөд Нийлүүлэгч нь өөрийн сувгаар цацагдаж буй аливаа нэвтрүүлэг, хөтөлбөрийн агуулгатай холбоотой маргаан, эрсдэлээс Дамжуулагчийг чөлөөлж, Дамжуулагчид аливаа нэр хүндийн эрсдэл үүсгэхгүй байх бүхий л нөхцөлийг хангаж ажиллана.
- 9.9 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас торгууль, алданги төлсөн явдал нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх үндэслэл болохгүй.
- 9.10 Талууд энэхүү гэрээний 10-р зүйлд зааснаас бусад тохиолдолд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх, түүнчлэн хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэлгүй болно.

АРАВ. ГЭНЭТИЙН БОЛОН ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

- 10.1 Энэхүү гэрээний хугацаанд гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас аль нэг тал гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх боломжгүй бол энэ талаар нөгөө талдаа бичгээр нэн даруй мэдэгдэнэ.
- 10.2 Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал гэдэгт гэрээний талуудаас хяналтаас гадуур урьдчилан таамаглах боломжгүй, талууд гэрээгээр хүлээх үүргээ биелүүлэх боломжгүй нөхцөл байдлыг ойлгох бөгөөд үүнд байгалийн гамшиг, олон улсын шинжтэй хил боомт хаагдах, ажил хаялт, дайн, дайн бүхий байдал, өвчин тахал, хорио цээр, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр зэрэг хамаарах ба аль нэг талын буюу тухайн талын төлөөлөгч, ажилтны хайхрамжгүй байдал, санаатай үйлдлийн улмаас үүссэн аливаа үйл явдал хамаарахгүй.
- 10.3 Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын нөлөөнд өртсөн тал нь давагдашгүй хүчин зүйлийн үр дагавар, талуудын эд хөрөнгө, ажиллагсдын эрүүл мэндэд учирч болох хохирлыг багасгах талаар шуурхай арга хэмжээ авах үүрэгтэй. Ийнхүү сайн дурын үндсэн дээр өөрөөс шалтгаалах бүх арга хэмжээг авсан бол хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэл болно.
- 10.4 Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас учирсан хохирол, нөхцөл байдлыг аль болох богино хугацаанд сэргээх ажлыг талууд тохиролцон авч хэрэгжүүлэх ба энэ үед тухайн нөхцөл байдлыг зөвөөр үнэлэн, эрсдэлийг хуваарилах талаар тохиролцож болно. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдалтай холбогдуулан аль нэг талд зардал гарсан тохиолдолд уг зардлыг тухайн тал өөрийн хөрөнгөөр дангаар хариуцна.

- 10.5 Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас Гэрээний хэрэгжилт хуанлийн 30 (гуч)-аас дээш хоногийн хугацаагаар бүхэлдээ буюу хэсэгчлэн саатсан тохиолдолд аль нэг тал нь нөгөө талдаа хандан Гэрээг дуусгавар болгох тухай хүсэлтээ бичгээр мэдэгдэж, харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

АРВАН НЭГ. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ, ЦУЦЛАХ

- 11.1 Гэрээнд заасан үүргийг Талууд зохих ёсоор гүйцэтгэсэн бөгөөд гэрээний хугацаа дуусгавар болсон, эсхүл хуулийн этгээд үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон, эрх залгамжлалгүйгээр татан буугдсан, дампуурснаа албан ёсоор зарласан, улсын бүртгэлээс хасагдсан зэрэг тохиолдолд гэрээ дуусгавар болно.
- 11.2 Талуудын аль нэг нь гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй эсвэл удаа дараа (2 ба түүнээс дээш удааг ойлгоно) биелүүлээгүй тохиолдолд нөгөө талдаа гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардсан албан бичиг хүргүүлэх бөгөөд хүргүүлснээс хойш ажлын (5) өдрийн дотор тухайн гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд нөгөө талдаа гэрээг цуцлах тухай санал гаргаж болох ба уг саналыг бичгээр гаргана.
- 11.3 Талууд харилцан хэлэлцэн тохиролцсоны үндсэн дээр гэрээг цуцалж болно.
- 11.4 Талуудын аль нэг нь Гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах хүсэлтэй бол энэ тухайгаа нөгөө талдаа хуанлийн 30 (гуч)-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдэл хүргүүлэх ба уг мэдэгдлийн хүлээн авсан тал тогтоосон хугацаанд хариу ирүүлээгүй бол мэдэгдэлд дурдсан хугацаа өнгөрмөгц гэрээ цуцлах саналыг зөвшөөрсөнд тооцно.
- 11.5 **Дамжуулагчийн санаачилгаар гэрээг цуцлах:** Дор дурдсан тохиолдлуудад энэхүү гэрээ Дамжуулагчийн санаачилгаар нэн даруй цуцлагдах ба Дамжуулагч нь өөрийн санаачилгаар гэрээг цуцалсантай холбогдуулан Нийлүүлэгчид орох байсан орлого, ашиг, аливаа хохирол, зардал зэргийг нөхөн төлөх үүрэг хүлээхгүй:
- 11.5.1 Нийлүүлэгч нь гэрээний үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүй бөгөөд Дамжуулагчийн тогтоосон хугацаанд зөрчлийг арилгах үүргээ биелүүлээгүй;
- 11.5.2 Нийлүүлэгч нь 3 (гурав) сараас дээш хугацаанд сувгийн эфирийг өгөөгүй;
- 11.5.3 Нийлүүлэгчийн гаргасан мэдэгдэл, баталгаа нь хуурамч, худал мэдээлэл агуулсан болох нь илэрхий болсон эсхүл мэдэгдэл, баталгааг зөрчсөн;
- 11.5.4 Нийлүүлэгчийн телевизийн тусгай зөвшөөрлийн хугацаа дуусгавар болсон, эсхүл эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон.
- 11.6 Гэрээний 11.5-д заасны дагуу гэрээ цуцлагдсан тохиолдолд Дамжуулагч нь тухайн сувгийн дугаарлалтыг хадгалах үүрэг хүлээхгүй.

АРВАН ХОЁР. НУУЦЛАЛ

- 12.1. Талууд энэхүү гэрээг хэрэгжүүлэх явцад шууд болон шууд бусаар олж мэдсэн бизнесийн нууц, нийтэд ил болгоогүй аливаа мэдээлэл, баримт бичгийн нууцлалыг чандлан хадгалах, хамгаалах арга хэмжээ авах, бусдад алдагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах үүрэгтэй ба нөгөө талаас урьдчилан бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр дараах үйлдлийг хийхийг хориглоно:
- 12.1.1. Задруулах, олшруулах, түгээх;
- 12.1.2. Өөрт болон гуравдагч этгээдэд ашиг олох, давуу байдал тогтоох зорилгоор нууц мэдээллийг бусад байдлаар ашиглах;
- 12.2. “Нууц мэдээлэл” гэдэгт Талуудын хамтын ажиллагааны явцад шууд болон шууд бус замаар олж мэдсэн, авсан, мэдэх болон авах боломжтой аливаа мэдээлэл, программ хангамж, биллинг систем, хэрэглэгчийн хувийн мэдээлэл (овог нэр, хаяг, бусад), бараа худалдах, тээвэрлэх, түгээх маршрут, үйл явц болон техник технологи (ноу-хау мөн хамаарна), компанийн бүтэц, зохион байгуулалт, төсөв, бизнес төлөвлөгөө, дүрэм, журам, зах зээлд гаргаагүй байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх мэдээлэл, гэрээ, хэлцэл, баримт материал, эх хувь болон хуулбар, ноорог, цахим хэлбэрээр дамжуулсан файл, аман хэлбэрээр уламжилсан мэдээ мэдээлэл, үйлчлүүлэгчийн зүгээс бусад гуравдагч этгээдтэй хийсэн аливаа хэлэлцээр, уулзалтын тов, хэлэлцэгдэж буй асуудлууд болон хамтын ажиллагааны хүрээнд үүссэн аливаа мэдээлэл, баримт бичиг, биет зүйлийг ойлгох бөгөөд эдгээр мэдээлэл нь бичгэн, цахим, аман аль ч хэлбэрээр байж болно.
- 12.3. Дараах нөхцөл байдал нотлогдсон тохиолдолд Талуудын мэдээллийн нууцлалыг хангах үүрэгт үл хамаарна:
- 12.3.1. Тухайн мэдээлэл олон нийтэд ил болсон;
- 12.3.2. Шүүх, хуулиар тогтоосон эрх бүхий байгууллагын шийдвэрээр эсхүл хуульд заасны дагуу мэдээллийг нийтэд ил болгох, задруулах шаардлагатай болсон;

- 12.4. Энэ гэрээний 12.3-т зааснаас бусад тохиолдолд, аль нэг тал нь мэдээллийн нууцыг чанд хадгалах үүргээ биелүүлээгүй, биелүүлэхээс татгалзсан, нууцыг задруулсан аливаа үйлдэл, эс үйлдэхүйн улмаас нөгөө талдаа учирсан зардал, хохирлыг гэм буруутай тал бүрэн барагдуулна.

АРВАН ГУРАВ. БУСАД ЗҮЙЛ

- 13.1. **Гэрээ хүчин төгөлдөр болох:** Энэхүү гэрээнд Талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
- 13.2. **Гэрээний эх хувь:** Гэрээг Монгол хэл дээр 2 (хоёр) эх хувь үйлдэж, тал тус бүр нэг нэг хувийг хадгалах бөгөөд хувь тус бүр хууль зүйн адил хүчинтэй байна.
- 13.3. **Эрх шилжүүлэх:** Аль нэг тал энэхүү гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг, хариуцлагаа нөгөө талын бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй.
- 13.4. **Нэмэлт өөрчлөлт:** Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг Талууд харилцан тохиролцож, нэмэлт гэрээ байгуулсны үндсэн дээр шийдвэрлэнэ. Аль нэг тал гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах саналаа нөгөө талд бичгээр хүргүүлэх ба саналыг хүлээн авсан тал ажлын 3 (гурав) өдөрт багтаан хариу хүргэнэ.
- 13.5. **Маргаан шийдвэрлэх:**
- 13.5.1. Энэхүү гэрээний нөхцөл, зааглах цэг, төлбөр, энэхүү журам болон гэрээг зөрчсөн, өрсөлдөөний эсрэг үйлдэл гаргасан болон гэрээний үүргийн биелэлттэй холбоотой маргааныг талууд эвийн журмаар зөвшилцлийн үндсэн дээр шийдвэрлэхийг зорих бөгөөд шийдвэрлэж чадахгүй тохиолдолд Харилцаа холбооны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь заалтын дагуу Харилцаа Холбооны Зохицуулах Хороонд хандаж шийдвэрлүүлнэ.
- 13.5.2. Энэхүү Гэрээний 12.1 дүгээр зүйлд заасны дагуу Харилцаа Холбооны Зохицуулах Хороонд хандаж шийдвэрлүүлсний дараа талууд харилцан тохиролцож чадаагүй тохиолдолд маргаанаа Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 13.5.3. Гэрээтэй холбогдсон аливаа маргаантай асуудлыг хянан шийдвэрлэхэд Монгол Улсын хууль тогтоомжийг хэрэглэнэ.
- 13.6. **Гэрээний хүчин төгөлдөр байдал:**
- 13.6.1 Талуудын эрх бүхий төлөөлөгчид өөрчлөгдсөн эсэхээс үл хамааран энэхүү гэрээнд заасан хугацаанд гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 13.6.2 Энэхүү гэрээний аливаа зүйл заалт хууль тогтоомжид орсон өөрчлөлт, бусад байдлаас шалтгаалан хүчин төгөлдөр бусд тооцогдсон нь гэрээний бусад зүйл заалтын хүчин төгөлдөр байдалд нөлөөлөхгүй. Энэ тохиолдолд талууд гэрээний тухайн заалтыг хуульд заасан шаардлагад нийцүүлэн өөрчлөх байдлаар гэрээг хэрэгжүүлнэ.
- 13.6.3 Гэрээний нууцлал, хариуцлага болон шаардах эрхтэй холбоотой заалтууд нь энэ гэрээ цуцлагдсан, дуусгавар болсон эсэхээс үл хамааран хүчин төгөлдөр байдал нь хугацаагүй үргэлжилнэ.
- 13.7 **Талууд харилцах:** Талууд нэг нэгэндээ хандан гаргасан аливаа мэдэгдлийг цахим болон бичгийн хэлбэрээр Хавсралт 2-т заасан албан хаягийн дагуу илгээнэ. Аль нэгт тал нь энд заасан албан хаягийн мэдээлэлд өөрчлөлт оруулах бол нөгөө талдаа ажлын 5 (тав) өдрийн өмнө бичгээр мэдэгдэнэ. Ийнхүү мэдэгдээгүйгээс үүссэн аливаа хохирол, зардлыг мэдэгдээгүй тал нь бүрэн хариуцна.

13.7.1 Нийлүүлэгч:

Нэр: _____
Албан тушаал: _____
Утас: _____
Цахим хаяг: _____
Хаяг: _____

13.7.2 Дамжуулагч:

Хариуцсан ажилтны нэр: _____
Албан тушаал: _____
Утас: _____
И-мэйл: _____
Хаяг: _____

Монгол улс, Улаанбаатар 14200, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай 2, Сэнтрал тауэр, 8 давхар

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Дамжуулагч:

“ЮНИВИШН”ХХК-ийг төлөөлж

Г. БОЛОРЧИМЭГ

Медиа, менежментийн

Албаны захирал

Б. УНДРАМ

Медиа, хамтын ажиллагааны

Хэлтсийн менежер

Нийлүүлэгч:

“[•]” ХХК-ийг төлөөлж

.....

НЭГ. ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

4. Нийлүүлэгч нь дор дурдсан шаардлагын дагуу Сувгийг харилцан холболтын ЗААГЛАХ ЦЭГ буюу Юнител ХХК-ийн Дата төвд хүргэнэ.
5. Нийлүүлэгчийн нэвтрүүлгийн чанар нь MNS-5592-2 стандартын тоон телевизийн үндсэн үзүүлэлтүүдийн дагуу дараах хүснэгтэд заасан шаардлагыг хангасан байна.

а. ИНТЕРФЕЙС

Дүрсний оролт	SMPTE 259M (SD-SDI) /Хэрвээ HD форматаар дамжуулах бол SMPTE 292M (HD-SDI)/
Дууны оролт	Embedded audio (Дүрсний сигналд нь суулгасан аудио сигнал)

б. ДҮРСНИЙ ҮЗҮҮЛЭЛТ

Дүрсний харьцаа	4:3 /Хэрвээ HD форматаар дамжуулах бол 16:9/
SD нягтрал болон фреймрейт	576i@25
HD нягтрал болон фреймрейт	1080i@25

с. ДУУНЫ ҮЗҮҮЛЭЛТ

Дууны кодлол	Стерео хос
Дууны түвшин	-18dbFs (0db) EBU R128 мөрдөх

6. Дамжуулагч нь Нийлүүлэгчийн Сувгийг дараах стандартын дагуу сансрын хиймэл дагуулаар дамжуулж хэрэглэгчдэд хүргэнэ.

а. ДҮРСНИЙ ҮЗҮҮЛЭЛТ


Дүрсний шахалт болон битрейт H.264 4:2:0 кодлуур	
MPEG-4 MP@ML	SD 0.3 to 5 Mbps (VBR) /HD 0.3 to 15 Mbps (VBR)/
Дүрсний харьцаа	SD 4:3 /HD16:9/

б. ДУУНЫ ҮЗҮҮЛЭЛТ

Дууны формат	MPEG-1 Layer I, MPEG-1 Layer II
Дууны кодлол	Stereo

4. Дээрх стандартуудад нийцсэн эсэхэд чанарын үнэлгээ өгөх хэмжилт нь **УЛИРАЛД НЭГ УДАА** хийгдэнэ. Дамжуулагч нь Нийлүүлэгчээс шалтгаалан Сувагт гарсан гологдол, саатлыг Нийлүүлэгчид мэдэгдэж, гологдол, саатлыг арилгахыг шаардана.
5. “ЗААГЛАХ ЦЭГ”-д буюу Дата төв дээр ирж буй Нийлүүлэгчийн шилэн кабелийн үзүүр болон төхөөрөмж нь тухай телевизийн Дамжуулагчид өгч буй дамжуулалтын хувьд эцсийн цэг байна.
6. Нийлүүлэгчийн Сувгийн студиас “ЗААГЛАХ ЦЭГ”-ын хувиргалтын төхөөрөмжийн оролт хүртэлх дамжуулалтын трактын /оптик төхөөрөмж/ хэвийн найдвартай ажиллагааг хангах асуудлыг Нийлүүлэгч бүрэн хариуцна.

ХОЁР. СУВАГ БОЛОН ДАМЖУУЛАГЧИЙН СҮЛЖЭЭ ХООРОНДЫН
ХАРИЛЦАН ХОЛБОЛТЫН ЗААГЛАХ ЦЭГ,
ЗУРАГЛАЛ(УЛААНБААТАР ХОТ)



(Зааглах цэг нь УБ хот ХУД 4-р хороо Дата Центр 3 давхар G-1 зогсуур)

ХАВСРАЛТ БАТАЛСАН:

Дамжуулагч:

“ЮНИВИШН”ХХК-ийг төлөөлж

Нийлүүлэгч:

“[.]” ХХК-ийг төлөөлж


Б. УНДРАМ

Медиа, хамтын ажиллагааны
Хэлтсийн менежер

.....

(Орон нутгийн телевизтэй байгуулах гэрээнд орох хувилбар)

**ХОЁР. СУВАГ БОЛОН ДАМЖУУЛАГЧИЙН СҮЛЖЭЭ ХООРОНДЫН
ХАРИЛЦАН ХОЛБОЛТЫН ЗААГЛАХ ЦЭГ,
ЗУРАГЛАЛ (ОРОН НУТАГ)**



(Зааглах цэг нь Орон нутаг дахь Мэдээлэл Холбооны Сүлжээ ХХК-ийн байр)

ХАВСРАЛТ БАТАЛСАН:

Дамжуулагч:

“ЮНИВИШН” ХХК-ийг төлөөлж

Б. УНДРАМ

Медиа, хамтын ажиллагааны
Хэлтсийн менежер

Нийлүүлэгч:

“[•]” ХХК-ийг төлөөлж

.....

ХОЁР. ТАЛУУДЫН ХАРИЛЦАН ХОЛБОО БАРИХ МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН МЭДЭЭЛЭЛ

“UNIVISION” ХХК-ний зүгээс:

1.	Техникийн холбогдолтой асуудал гарсан үед:	<i>Сүлжээ хяналтын инженер, утас: 77007740, 89118042, и-мэйл хаяг: omc@unitel.mn</i>
2.	Санхүүгийн холбогдолтой асуудал гарсан үед:	<i>М. Отгонжаргал /Нягтлан бодогч,/ Утас: 86110987, и-мэйл хаяг: otgonjargal.m@unitel.mn</i>
3.	Маркетингийн холбогдолтой асуудал гарсан үед:	<i>Т. Лхам Төлөвлөлтийн ахлах мэргэжилтэн Утас: 89110263, и-мэйл хаяг: lkham.t@unitel.mn</i>
4.	Гэрээ болон контентын асуудал гарсан үед:	<i>Т. Дунгаамаа Медиа хамтын ажиллагааны мэргэжилтэн Утас:89118885 и-мэйл хаяг: dungaamaa.t@unitel.mn</i>

Нийлүүлэгчийн зүгээс:

1.	Техникийн холбогдолтой асуудал гарсан үед:
2.	ТВ-ийн хөтөлбөртэй холбоотой өөрчлөлт гарсан үед:
3.	Санхүүгийн холбогдолтой асуудал гарсан үед:
4.	Маркетингийн холбогдолтой асуудал гарсан үед:

Тайлбар:

Гэмтэл, сааталтай холбоотой тусгай журамлал: Аль нэг талд техниктэй холбоотой ямар нэг гэмтэл, саатал, асуудал гарсан тохиолдолд шаардлагатай гэж үзвэл талуудын инженерүүд бие биетэйгээ түргэн, шуурхай холбогдож, хамтран ажиллаж, тухайн асуудлыг шийдвэрлэхийг эрхэмлэнэ. Нийлүүлэгчийн зүгээс техниктэй холбоотой ямар нэг гэмтэл, саатал, асуудал гарсны улмаас Ай Пи Ти Ви доголдож улмаар хэрэглэгч, үзэгчдийн зүгээс гомдол, санал гаргах, Ай Пи Ти Ви-ийн үйлчилгээ, нэр хүндэд сөргөөр нөлөөлөх аливаа нөхцөл байдал олон нийт, нийгмийн сэтгэл зүйд үүсэх, эсхүл ийм нөхцөл байдал хэдийн үүссэн байдаг тул Ай Пи Ти Ви-ийн зүгээс дээрх хүснэгтэд нэр дурдсан эсэхээс үл хамааран тухайн телевизийн холбогдох албан тушаалтан, шууд удирдлага зэрэгтэй холбоо барин шаардлагатай инженер, техникийн ажилтантай холбож өгөх талаар санал болгох эрхтэй. Тухайн телевизийн холбогдох албан тушаалтан, шууд удирдлага нь энэхүү санал, хүсэлтийг хүлээн авч, найрсаг, түргэн шуурхайгаар зохицуулж өгөх арга хэмжээ авах үүрэг хүлээнэ.

ХАВСРАЛТ БАТАЛСАН:

Дамжуулагч:

“ЮНИВИШН”ХХК-ийг төлөөлж

Нийлүүлэгч:

“[•]” ХХК-ийг төлөөлж

Б. УНДРАМ

Медиа, хамтын ажиллагааны
Хэлтсийн менежер

.....

НЭГ. СУВАГТ ГАРСАН ГЭМТЭЛ СААТЛЫГ ТООЦОХ ТУХАЙ

- 1.1 Дамжуулагчийн Ай Пи Ти Ви-ээр дамжиж байгаа Сувгийг чанарын өндөр түвшинд дамжуулж хэрэглэгчдэд хүргэх зорилтыг хэрэгжүүлэхэд энэхүү зарчим мөрдөгдөнө.
- 1.2 Сувгийн эх үүсвэр болох телевизийн камер студийн оролтын төхөөрөмжөөс уг нэвтрүүлгийг хүлээн авч үзэж байгаа эцсийн хэрэглэгч хүртэлх орон зайг нэвтрүүлгийн бүрэн тракт гэнэ.
- 1.3 Сувгийн бүрэн трактын тасралтгүй хэвийн ажиллагааг хангаж нэвтрүүлгийг доголдол сааталгүй дамжуулах үүргийг бүрэн трактанд хамрагдан ажиллаж байгаа бүх хүн адил тэгш хүлээж, хамтран ажиллана. Сувагт тавигдах үндсэн шаардлага нь Монгол улсын MNS:5592-2 стандартад заагдсан нормыг баримтална.
- 1.4 Сувгийн доголдол саатлыг дүрсний, дууны гэж ангилан гарсан тухай бүр нь дээрх чиглэлээр цаг хугацааг тооцож, хамтран ажиллагчид харилцан шалгалт хэмжилтийг хийж богино хугацаанд арилгах бүх талын арга хэмжээг шуурхай хэрэгжүүлнэ.
- 1.5 Талуудын зааглах цэгийн байршил нь УБ хот, ХУД-ийн 4-р хороо, Дата центр, 3 давхар G-1 зогсуур байх бөгөөд уг цэгээс дотогш өөрт хамаарч буй тоног төхөөрөмж, шилэн кабелийн ашиглалт, үйлчилгээний найдвартай хэвийн ажиллагааг талууд бүрэн хариуцна.
- 1.6 Гэмтэл саатал гарсан тохиолдолд Талууд өөр өөрсдийн зааглах цэгээс дотогш гарсан гэмтэл саатлыг бие даан хариуцах ба Нийлүүлэгч өөрийн талд үүссэн гэмтэл саатлыг Дамжуулагчаар засварлуулах хүсэлт гаргасан бол гарсан зардлыг хариуцан төлнө.
- 1.7 Эрчим хүчний найдвартай ажиллагааг Талууд өөрсдийн хариуцах талдаа хангана.
- 1.8 Сувгийн холболтын тоног төхөөрөмжид дур мэдэн өөрчлөлт оруулахгүй байх үүрэгтэй.
- 1.9 Нийлүүлэгч нь анх холболт хийсэн хаягаас нүүх тохиолдолд тоног төхөөрөмжийг шилжүүлэх, дахин холбохтой холбогдон гарах зардлыг дангаар хариуцна.
- 1.10 Талууд үйлчилгээний чанар нь стандарт түвшинд хэвийн ажиллаж байгаа эсэхэд хяналт тавих бөгөөд Нийлүүлэгчийн үйлчилгээний чанар нь стандарт түвшинд хүрэхгүй бол тухай бүр Дамжуулагч нь Нийлүүлэгчийн ажилтанд холбогдох мэдээллийг хүргэж шуурхай арга хэмжээ авч хамтран ажиллана.
- 1.11 Талууд аливаа гэмтэл саатал гарсан үед холбогдох мэдээллийг хүргэх бөгөөд үүссэн гэмтэл сааталд шуурхай арга хэмжээ авч засварлан ажиллана.
- 1.12 Үйлчилгээний системд өөрчлөлт шинэчлэлт оруулах, Техникийн зайлшгүй шалтгааны улмаас түр хугацаанд систем дээр төлөвлөгөөт ажил хийхээр бол гэрээнд заасны дагуу мэдээллийг хүргэж ажиллана.

ХАВСРАЛТ БАТАЛСАН:

Дамжуулагч:

“ЮНИВИШН”ХХК-ийг төлөөлж

Нийлүүлэгч:

“[•]” ХХК-ийг төлөөлж

Б. УНДРАМ

Медиа, хамтын ажиллагааны
Хэлтсийн менежер

.....

ХӨТӨЛБӨР ӨГӨХ ФОРМАТ

1. Хөтөлбөрийн нэрийг монгол хэлний зөв бичгийн дүрмийн дагуу алдаагүй зөв бичсэн байх.
2. Монгол хэлний зөв бичгийн дүрэм, монгол хэлний найруулга зүй, өгүүлбэрийн бүтцийн тогтсон дэгийг мөрдөх.
3. Хөтөлбөрийн нэрний эхний үгийн эхний үсэг том үсгээр бусад үсэг жижиг үсгээр бичсэн байх.
4. Хөтөлбөрийн нэрний үг хооронд 1 мөрний зай авах.
5. Өдөр бүрийн эфирийн төгсгөлд заавал "Эфир завсарлага, Эфир хаасан" эсвэл "Эфир завсарласан" гэж хөтөлбөрийг төгсгөх.
6. Он сар өдөр (YYYY-MM-DD), цагийн формат-(hh:mm) форматын дагуу байх.
7. Гадаад нэршлийг монгол хэлэнд орчуулсан байх.
8. Товчилсон үг нэршил ашиглахгүй нэрийг бүтнээр бичсэн байх.
9. Хөтөлбөрийг Excel формат дээр бэлдсэн байх.
10. Нэвтрүүлгийн нэрээ 30 тэмдэгтэд багтаан бичих.
11. Хөтөлбөрийн засварыг ирүүлэхдээ хөтөлбөрийн форматын дагуу бэлтгэж засвар орсноос хойш тухайн 7 хоногийн Ням гараг хүртэлх хөтөлбөр илгээнэ.
12. Хөтөлбөрт засвар орсон хэсгийг тодотгож ирүүлэх.
13. Хөтөлбөр илгээх хугацаанаасаа хоцорч ирүүлсэн хөтөлбөр нь ажлын өдөр 24 цагийн дараах хөтөлбөрөөс эхлэн системд орно.
14. Хөтөлбөр зөв бичих дүрмийн алдаа, цагийн алдаа, форматын алдаатай хөтөлбөр илгээсэн тохиолдолд хөтөлбөр системд орох боломжгүй.

ЗУРАГТАЙ ХӨТӨЛБӨР ИРҮҮЛЭХ ФОРМАТ

1. Хөтөлбөр бүр зурагтай байх тул зураг бүрэн байх.
2. 7 хоног бүрийн хөтөлбөрийн хамт шинэ хөтөлбөрийн зургаа хамтатган ирүүлэх.
3. Хөтөлбөрийн нэр болон зургийн нэршил ижил байна. Хөтөлбөрийн нэршлийг өөрчлөхөд шинээр зураг бэлтгэн илгээнэ.
4. Зурагны хэмжээ:1920x1080 , JPG форматтай, 1mb-с ихгүй байх.
5. Зураг форматын дагуу ирүүлээгүй болон бүрэн биш тохиолдолд системд хөтөлбөр орохгүй байх тул дээрх шаардлагуудын дагуу бүрэн ирүүлэх.

Хөтөлбөр бичих хүснэгтийн загвар:

Он сар өдөр	Цаг	Хөтөлбөрийн нэр
2021-03-10	9:00

ХАВСРАЛТ БАТАЛСАН:

Дамжуулагчийг төлөөлж:
"ЮНИВИШН"ХХК-ИЙН

Нийлүүлэгчийг төлөөлж:
"[·]" ХХК-ИЙН

Б. УНДРАМ
Медиа, хамтын ажиллагааны
Хэлтсийн менежер

.....

Өргөн нэвтрүүлгийн Телевизийн сувгийг дамжуулахтай холбоотой зардал

№	Зардлын нэр төрөл	Холболтын төрөл	Суваг дамжуулалтын төлбөр ₮	
			УБ хот	Орон нутаг
1	Шилэн кабель, урсгал түрээсийн төлбөр	HD	...₮	...₮

Тайлбар:

“Сүлжээ хооронд харилцан холболт хийх, сүлжээнд холбогдох гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журам”-ын 2.9-д зааснаар дээрх төлбөрийн хэмжээг тогтоохдоо бизнесийн аливаа алдагдлыг нөхөх зорилго агуулахгүй байх зарчмыг баримтална.

ХАВСРАЛТ БАТАЛСАН:

Дамжуулагч:

“ЮНИВИШН”ХХК-ийг төлөөлж

Нийлүүлэгч:

“[•]” ХХК-ийг төлөөлж

Б. УНДРАМ

Медиа, хамтын ажиллагааны

Хэлтсийн менежер

ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН МЭДЭЭЛЭЛ

Холболтын техник, төхөөрөмжийн нэр, зориулалт	Нийлүүлэгч талд УБ	Нийлүүлэгч талд ОН	Дамжуулагч талд(ОСДҮЭ)
Хөрвүүлэх төхөөрөмж(Encoder) түүний төрөл, марк, дугаар		“Dexin” Encoder	“Envivio” encoder
Дамжуулах(Тх)/Хүлээн авах(Rx) төхөөрөмж түүний төрөл марк, сериал дугаар	Blackmagic Mini converter Optical Fiber	ONT or MDU	Blackmagic Mini converter Optical Fiber
Холбох шугамын төрөл, үзүүлэлт		Шилэн кабель	Телевизээс Дата төв хүртэл шилэн кабель 1 core шууд холболт
Холболтын интерфэйс	HD-SDI embeded signal телевизээс өгч Дата төв дээр хүлээн авна.	HD-SDI embeded signal телевизээс өгч Дата Центр төв дээр хүлээн авна.	HD-SDI embeded signal телевизээс өгч Дата Центр төв дээр хүлээн авна.
Бусад			

ХАВСРАЛТ БАТАЛСАН:

Дамжуулагч:

“ЮНИВИШН”ХХК-ийг төлөөлж

Нийлүүлэгч:

“[•]” ХХК-ийг төлөөлж

Б. УНДРАМ

Медиа, хамтын ажиллагааны

Хэлтсийн менежер